

**“МОНГОЛЫН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛ**

2023 оны 04 сарын 30-ний өдөр

№ 01

Улаанбаатар хот

“Монголын хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 4 дугаар сарын 30-ний өдөр 10.00 цагт Улаанбаатар хот, Хан уул дүүргийн 18-р хороо, Богд жавзандамба хутагтийн гудамж LS plaza төв 2 давхрын хурлын танхимд болов.

Хуралд компанийн хувьцаа эзэмшигч “Монгол 999 Үндэсний нэгдэл” ХК /захирал М.Отгонбаатар/, нийт гаргасан хувьцааны 45088 хувьцаа буюу нийт гаргасан хувьцааны 90,17 % хувийг эзэмшигчид хуралд оролцлоо. Хурлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Чүлтэмийн Амарбаатар удирдан явуулав.

Тооллогын комисс: Компанийн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 45088 ширхэг буюу 90,17 хувийг эзэмшигчид хуралд оролцож байгаа учраас Монгол улсын Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д заасны дагуу хурлын ирцыг хүчин төгөлдөрт тооцохыг мэдээлэв.

Хурлын дарга Ч.Амарбаатар:

За Тооллогын комисст баярлалаа. Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал нээснийг мэдэгдье.

Хурлын дарга хэлэлцэх асуудлыг танилцуулав.

Хурлаар хэлэлцэх асуудал

- Компанийн 2022 оны үйл ажилагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлт;
- Ногдол ашиг хувиарлахгүй талаар ТУЗ гаргасан шийдвэрийг танилцуулах;
- Компанийн цаашид хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн талаар хэлэлцэх;
- Компанийн дүрмэнд тусгасан зарласан хувьцаанаас, нэмж хувьцаа гаргах тухай ТУЗ-ийн тогтоолын төслийг танилцуулж, хэлэлцэж, батлах
- Компанийн дүрмийн өөрчлөлт
- ТУЗ гишүүдийг сонгох
- Бусад асуудал

Хурлын дарга Ч.Амарбаатар:

Хурлын дэгийг танилцуулав.

Хурлын дарга Ч.Амарбаатар:

Хурлын Дэгийн дагуу эхний хэлэлцэх асуудал Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар гүйцэтгэх захирал Т.Наранбулаг танилцуулна. Гүйцэтгэх захирал тайланг танилцуулав. /Тайланг хавсаргав/.

Хурлын дарга Ч.Амарбаатар:

Тайлантай холбогдуулаад асуух асуулт байна уу? Бид цаашид компанийн үйл ажиллагааг идэвхжүүлж ажиллахаар ажлын төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, ажиллах багийн төлөвлөгөө зэрэг асуудлыг ТУЗ ярилцаж байгаа, бэлтгэл ажлууд хийгдэж байгаа. Ингээд компанийн 2022 оны үйл ажиллагаанд ТУЗ-аас “хангалттай” гэсэн дүгнэлт өгсөн, одоо үр ашигтай ажиллацгаах болно.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг баталсугай.
2. Компанийн үйл ажиллагааг идэвхижүүлж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлд даалгасугай.

Хурлын дарга Ч.Амарбаатар:

Хурлын хэлэлцэх асуудлын дарааллалын дагуу Ногдол ашиг хувиарлахгүй талаар ТУЗ гаргасан шийдвэрийг танилцуулья.

Хурлын дарга Ч.Амарбаатар:

За дараагийн хэлэлцэх асуудалдаа орё. Компанийн цаашид хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн талаар хэлэлцэнэ.

“Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтөд чөлөөт бүсийн эзлэх байр суурь, хэрэгцээ шаардлага ямар их байгааг ялангуяа Монгол улс, ОХУ, БНХАУ-ийн 3 улсын эдийн засгийн коридорт Замын-Үүд, Эрээний хамтарсан чөлөөт бүсийн ач холбогдол нь өнөөгийн цар тахалын үед тээвэр логистикийн асар их ач холбогдолтойг нийтээрээ ойлгож байна.

Төр засгаас “Ковид 19” халдварт цар тахлын сорилт бэрхшээлийг даван туулж байгаа ч эдийн засгаа сэргээх урт хугацаанд олон тулгуурт дэд бүтцийг бий болгож, тогтвортой эдийн засгийн өсөлтийг дэмжиж үүднээс Замын-үүдийн чөлөөт бүсийг яаралтай нээж чөлөөт бүсийн горимийг ашиглахаар тодорхой шийдвэр гарсан мөн Замын-Үүд Эрээний эдийн засаг хамтын ажиллагааны чөлөөт бүс байгуулахаар тохирсон олон улсын хэлэлцээрийг хоёр жил гацсан байсныг УИХ-аар 2021 оны арванхоёрдугаар сарын 23-ны өдөр соёрхон баталсан нь манай компанийн цаашдын хөгжилд түлхэц болж байна.

“Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогод бүс нутгийн хамтын ажиллагаа, чөлөөт бүсүүдийг дэмжин хөгжүүлэх тухай тусгагдсан нь гадаад болон дотны хөрөнгө оруулагчдад монгол улс нээлттэй гэдгээ зарласан үйл явдал болсон. Олон улсын чөлөөт бүсэд мега төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд “Чөлөөт бүсийн хөрөнгө оруулалтын корпораци /ЧБХОК/, Менежментийн компани, Хөгжлийн компани” гэсэн зохистой харилцаанд тулгуурладаг тул засаглалын хувьд тогтвортой хэрэгжих боломжийг хангаж өгөх хэрэгтэй байна.

Иймд Монголын эдийн засгийг нуруун дээр үүрдэг компаниудын нэгдэл болох МҮХАҮТ-ийн удирдлага дор хөрөнгө оруулалтыг төр хувийн хэвслүүдийн хамтарсан “Чөлөөт бүсийн хөрөнгө оруулалтын корпораци”, “Менежментийн компани”, “Хөгжлийн компани” байгуулах асуудлыг ТУЗ-аас оруулж байна.

Мөн Компанийн үйл ажиллагаа, цар хүрээг нэмэгдүүлэх хөрөнгө оруулах болон нэмж хувьцаа гаргах үүднээс Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.3 дахь заалт, компанийн Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.7.3 дахь заалт үндэслэн Монголын чөлөөт бүсүүдийг Евро азийн эдийн засгийн коридорын нэг цогц төсөл болгон хөгжүүлэх, Замын үүд Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны чөлөөт бүсийн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хөгжүүлэх менежментийн компани болох, “Алтанбулаг, Замын-үүд чөлөөт бүс дамнасан цайны зам АН-3 хонгилын олон улсын авто тээвэр, ложистикийн цогцолбор”-ийн төсөл, Хөшигийн хөндийн чөлөөт бүсийн бүтээн байгуулалтын төслүүдийг дэмжиж Компанийн зарласан боловч гаргаагүй 999, 950,000 /есөн зуун ерэн есөн сая есөн зуун тавин мянган/ ширхэг, 99,995,000,000 /ерэн есөн тэрбум есөн зуун ерэн таван сая/ төгрөгийн үнэ бүхий хувьцааг эргэлтэнд оруулахаар төлөвлөж байгааг дэмжиж өгнө үү.

М.Отгонбаатар

Монгол улсын Их хурлын 2020 оны 05 сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг, 2020 оны 8 сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолоор Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг баталж, хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газарт үүрэг болгосон. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас компанийн үйл ажиллагаа, цар хүрээг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулах болон нэмж хувьцаа гаргахыг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгон даалгасан ба энэ эрхийг хэрэгжүүлэх бүрэн эрхийг ТУЗ-д дүрмээрээ олгосон. Энэхүү тогтоолын хүрээнд бид “Монголын хөгжил үндэсний нэгдэл” ХК нь төслийн санхүүжилтийг Монголын хөрөнгийн бирж дээр олон нийтэд санал болгон нэмж хувьцаа гаргах замаар хөрөнгө татан төвлөрүүлэх, үнэт цаас гаргах зэрэг хийгдэж ажлын төлөвлөгөө, санхүүгийн тооцоо, бүтэц зохион байгуулалт зэргийн талаар нарийвчилсан судалгаа хийж байгаа бөгөөд энэхүү саналыг дэмжиж байна.

Ж.Жаргалсайхан

Төр, хувийн хэвслүүдийн хамтарсан хөрөнгө оруулалтын корпораци байна. Өөрөөр хэлбэл төрийн өмчит компани нь томоохон банк, хөрөнгө оруулалтын компаниудтай хамтран эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн хөрөнгө оруулалтын корпораци байгуулж, хувьцаат компанийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулна. Үндсэн чиг үүрэг нь:

- Засгийн газар банк томоохон компаниудтай холболт хийж, санхүүгийн гарц нээх
- Чөлөөт бүсийн бүтээн байгуулалт, хөрөнгө босгох, ашиглах, удирдах, хяналт тавих
- Хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгжид оруулсан төрийн өмчийн ашиглалтын менежмент, хяналтыг хариуцах
- Зах зээлийн механизмын дагуу холбогдох функциональ хөгжлийн компаниудад хөрөнгө оруулах эсвэл оролцох
- Холбогдох эдийн засгийн асуудлыг зохицуулах гэх мэт

Менежментийн компани

- Бүсийн ерөнхий төлөвлөгөө, эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах үүрэгтэй
- Эрх олгогдсон хүрээний газар төлөвлөлт, төлбөртэй шилжүүлэх, түрээслэх, ашиглах эрхийг шилжүүлэх, хэрэгжүүлэх, хянах, удирдах ажлыг хариуцна
- Хөрөнгө оруулалтын төслүүдийн менежментийн эрх мэдлийн хүрээнд бүтээн байгуулалтын төслүүдийг батлах, хариуцах
- Эдийн засгийн үйл ажиллагааны ерөнхий байдлыг хянах, дүн шижилгээ хийх үүрэгтэй

Хөгжлийн компани

- Дэд бүтцийн бүтээн байгуулалт
- Бизнесийн нэгжүүдийг хөгжүүлэх
- Барилга байгууламж, үл хөдлөх хөрөнгийн бүтээн байгуулалт
- Шинжлэх ухаан, инновацийн чиглэлд хөгжүүлэх
- Нийгмийн байгууламжуудыг бүтээн байгуулах
- Ногоон байгууламж, ландшафт гүйцэтгэх

Үүнд Засгийн газарт төлөвлөлтийн дагуу “тавцан” бэлтгэж хувийн хэвشلүүдийг хөгжлийн компаний удирлага зохион байгуулалтын дор хувийн хэвشلүүдийг оролцуулна. Ингэхдээ зөвхөн төлөвлөлтийн дагуу хийж гүйцэтгэх үүргийг хөгжлийн компани хүлээнэ. Иймд саналыг бүрэн дэмжиж байна.

М.Отгонбаатар:

2019 оноос өнөөдрийг хүртэл сүүлийн 3 жил гаруйн хугацаанд үндсэндээ Ковид-19 цар тахлын улмаас хөл хорио тавьж, дийлэнх аж ахуйн нэгж, байгууллагууд үйл ажиллагаа явуулж чадсангүй. Бид ч мөн адил ийм байдалд байлаа. Одоо харин цаашид үйл ажиллагаагаа идэвхжүүлэн, төсөл хөтөлбөрүүдээ хэрэгжүүлээд явах цаг хугацаа нь ирээд байна.

Монгол Улсын Засгийн газрын харъяа байгууллага (Замын-Үүдийн чөлөөт бүсийн захирагчийн алба, Хилийн цэрэг, Гааль, Мэргэжлийн хяналт, орон нутаг) нөгөө талаас Хөрөнгө оруулагч, хувийн хэвшил гэх мэт оролцогч талууд нь нэгдсэн нэг ойлголттой болох зайлшгүй шаардлагатай байна. Мөн Замын-Үүдийн чөлөөт бүсийн ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөг тодорхой болгох, ЭЗ-ийн хамтын ажиллагааны бүсэд хамтарч ажиллах зарчимууд болон концепцийг тодорхой болгох болон БНХАУ-ын чөлөөт бүсийг хөгжүүлсэн туршлагыг нутагшуулах шаардлагатай.

Засгийн газар, чиглэл бүрийн сангууд, Банк, Хөрөнгө оруулагч нарыг нэгтгэж нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх бүтэц үүснэ.

Монгол улс, ОХУ, БНХАУ гурван улсын эдийн засгийн коридорт Замын-Үүдийн чөлөөт бүс, нөгөө талаас БНХАУ-ын Эрээний чөлөөт бүстэй хамтран ажиллах ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөг МҮХАҮТ манлайлж, төр болон хувийн хэвшлийн хамтарсан менежментийн компанийг үүсгэх шаардлагатай байна. Төрд алтан хувьцаа эзэмшүүлсэн ч болж байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Саналын хуудсыг тоолж 100%-ийн саналаар компанийн үйл ажиллагаа, цар хүрээг нэмэгдүүлэх хөрөнгө оруулах болон нэмж хувьцаа гаргах үүднээс Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.3 дахь заалт, компанийн Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.7.3 дахь заалт үндэслэн Монголын чөлөөт бүсүүдийг Евро азийн эдийн засгийн коридорын нэг цогц төсөл болгон хөгжүүлэх, Замын үүд Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны чөлөөт бүсийн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хөгжүүлэх менежментийн компани болох, “Алтанбулаг, Замын-үүд чөлөөт бүс дамнасан цайны зам АН-3 хонгилын олон улсын авто тээвэр, ложистикийн цогцолбор”-ийн төсөл, Хөшигийн хөндийн чөлөөт бүсийн бүтээн байгуулалтын төслүүдийг дэмжиж Компанийн зарласан боловч гаргаагүй 999, 950,000 /есөн зуун ерэн есөн сая есөн зуун тавин мянган/ ширхэг, 99,995,000,000 /ерэн есөн тэрбум есөн зуун ерэн таван сая/ төгрөгийн үнэ бүхий хувьцааг эргэлтэнд оруулахаар дэмжив.

ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хорооноос доорх нэр бүхий хүмүүсийг ТУЗ-д нэр дэвшүүлснийг танилцуулав. Анкетийг танилцуулав. ТУЗ-ийн ердийн гишүүнд:

1. Ч.Амарбаатар
2. Ж.Жаргалсайхан
3. Т.Наранбулаг
4. Н.Мөнх-идэр
5. Д.Алтансүх
6. М.Отгонбаатар

ТУЗ-ийн хараат бус гишүүнд:

1. Г.Төрбаяр
2. Н.Шагдарсүрэн
3. А.Ариунсайн

Анкетийг танилцуулав.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 6 хүнийг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр сонгосугай.

1. Ч.Амарбаатар □ 100%-ийн саналаар дэмжив
2. Ж.Жаргалсайхан - 100%-ийн саналаар дэмжив
3. Т.Наранбулаг - 100%-ийн саналаар дэмжив
4. Н.Мөнх-идэр -100%-ийн саналаар дэмжив
5. Д. Алтансүх - 100%-ийн саналаар дэмжив
6. М.Отгонбаатар - 100%-ийн саналаар дэмжив

Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 3 хүнийг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосугай.

1. Г.Төрбаяр - 100%-ийн саналаар дэмжив
2. Н.Шагдарсүрэн - 100%-ийн саналаар дэмжив
3. А.Ариунсайн -100%-ийн саналаар дэмжив

Компанийн тухай хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг гишүүдэд үүрэг болгосугай.

Хэлэлцэх асуудал дууссан тул хурал 13 цаг 00 минутанд өндөрлөв.

Хурлын дарга Ч.Амарбаатар:

Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг хааж байна. Хуралд оролцсон та бүхэнд баярлалаа.

ХУРЛЫН ДАРГА:

/ Ч.АМАРБААТАР/

Хурлын тэмдэглэл хөтөлсөн :

/ С.ОТГОНЦЭЦЭГ//

